



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДЭРИЙН ЯАМ



УУРХАЙЧДЫН СПОРТЫН ИХ НААДАМ 2022

ҮҮРД ХАДГАЛАХ “ЦОМ”-ЫН ТӨЛӨӨХ
ОЛОН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН

УДИРДАМЖ





УУРХАЙЧДЫН СПОРТЫН ИХ НААДАМ 2022

ҮҮРД ХАДГАЛАХ "ЦОМ"-ЫН ТӨЛӨӨХ
ОЛОН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН

“УУРХАЙЧДЫН СПОРТЫН ИХ НААДАМ-2022” УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

1.1 Монгол Улсад уул уурхайн салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг орон даяар сурталчлах, уул уурхайн салбарын төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, ажилтан албан хаагчдыг биеийн тамир спортод өргөнөөр хамруулж, спортод хандах идэвх, сонирхлыг өрнүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, салбарын спортын аварга байгууллагыг тодруулахад оршино.

2.1

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү спортын наадмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Оюу Толгой” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтран зохион байгуулна.

2.2 Спортын их наадмын төрөл бүрэлдэхүүн:

Д/Д	СПОРТЫН ТӨРӨЛ	ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ	БАГ ДАХЬ ХҮНИЙ ТОО	БАГИЙН ТОО
1.	САГСАН БӨМБӨГ	БАГ	ЭР 10, ЭМ 10	ЭР 1, ЭМ 1
2.	ВОЛЕЙБОЛ	БАГ	ЭР 12, ЭМ 12	ЭР 1, ЭМ 1
3.	ШИРЭЭНИЙ ТЕННИС	БАГ	ЭР 3, ЭМ 3	ЭР 1, ЭМ 1
4.	ШАТАР	БАГ	ЭР 3, ЭМ 3	ЭР 1, ЭМ 1
5.	ДАРТС	ХОЛИМОГ БАГ	ЭР 2, ЭМ 1	ХОЛИМОГ 1

2.3 СПОРТЫН ИХ НААДМЫН ТОВ:

2.3 Спортын их наадам 2022 оны 11 дүгээр сарын 15-наас 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрүүдэд Эрдэнэт хотод зохион байгуулагдана.

2.3.1 Спортын их наадмын нээлтийн үйл ажиллагаа 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 13:00 цагт болно.

2.3.2 Шатрын тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 09:00 цагт эхэлнэ.

2.3.3 Ширээний теннисний тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 09:00 цагт эхэлнэ.

2.3.4 Волейболын тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 09:00 цагт эхэлнэ.

2.3.5 Сагсан бөмбөгийн тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 09:00 цагт эхэлнэ.

2.3.6 Дартсын тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 09:00 цагт эхэлнэ.

/Жич: Спортын их наадам зохион байгуулагдах газар болон дэлгэрэнгүй цагийн хуваарийг техникийн зөвлөгөөн дээр зарлана./

2.4 Спортын их наадамд оролцох баг тамирчдын мэдүүлгийг хүлээн авах:

Спортын их наадамд оролцох баг, тамирчдын мэдүүлгийг төрөл тус бүрээр хавсралт мэдүүлгийн дагуу гарган, баталгаажуулсан байх бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүртэл ажлын цагаар дараах нотлох баримтуудын хамт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаман дээр хүлээн авна.

2.4.1 Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт /E-Mongolia цахим системээс авсан байх/;

2.4.2 Иргэний үнэмлэхний тодорхойлолт /E-Mongolia цахим системээс авсан байх/;



2.4.3 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зургийг файлаар ирүүлэх /Сүүлийн 3 сарын зураг байх/;

2.4.3 Тамирчин бүрийн E-Mongolia цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт /PDF/, иргэний үнэмлэхний тодорхойлолт/PDF/, цээж зургийг /JPG/ файлаар **Bolortuya@mmhi.gov.mn** цахим шуудангийн хаягаар ирүүлэх.

/Жич: Иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэрийн эх хувь болон бусад холбогдох нотлох баримтыг тамирчид биедээ авч явах./

/Жич: Баг, тамирчдын мэдүүлгийг спортын их наадмын төрөл тус бүрээр эрэгтэй, эмэгтэй багаар гарган баталгаажуулж ирүүлэхийг анхаарна уу. Баримт бичиг дутуу болон эрэгтэй эмэгтэй багаар нэгтгэж ирүүлсэн мэдүүлгийг хүлээн авахгүй болно./

2.5 Спортын их наадмын техникийн зөвлөгөөн:

2.5.1 Спортын их наадмын техникийн зөвлөгөөнийг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 14.00 цагт Улаанбаатар хотод Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хурлын танхимд зохион байгуулна;

2.5.2 Техникийн зөвлөгөөнд тухайн байгууллагыг төлөөлж зөвхөн 1 төлөөлөгч оролцоно;

2.5.3 Мэдүүлэг ирүүлсэн багийн тооноос хамаарч тоглолтын хэсгийн хуваарь, сугалааг сугалах, тоглолтын дүрэм болон бусад асуудлыг Техникийн зөвлөгөөнөөр хэлэлцэнэ;

2.5.4 Байгууллагууд техникийн зөвлөгөөнд оролцохдоо спорт зааланд байрлуулах тугийг зохион байгуулчдад хүлээлгэн өгнө.

ГУРАВ. БАГ, ТАМИРЧДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Спортын их наадамд оролцох байгууллагыг төлөөлөх багийн ахлагч нь тухайн байгууллагаас томилогдсон төлөөлөгч байна. Багийн ахлагч нь Спортын их наадамд оролцох баг, тамирчдыг удирдаж, хариуцна.

3.2 Спортын их наадамд оролцох тамирчин нь тухайн байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдон ажиллаж байгаа үндсэн ажилтан /гэрээт ажилтан, оюутан хамруулахгүй/ байна.

/Үндсэн ажилтан гэдэг нь тухайн байгууллагад зөвхөн “01” кодоор нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажилтан байна. Хэрвээ өөр байгууллагад “01” кодоор нийгмийн даатгалын шимтгэл давхар төлсөн тохиолдолд үндсэн ажилтанд тооцохгүй бөгөөд спортын наадамд оролцуулахгүй./

3.3 Багийн бүрэлдэхүүнд удирдамжийн 3.2-т заасан шаардлагыг хангасан лигийн тамирчинг оролцохыг зөвшөөрөх бөгөөд талбай дээр 2 лигийн тамирчинг тоглолтод оролцуулна. “Лигийн тамирчин” гэдэг нь дараах тэмцээнүүдэд оролцсон тамирчдыг хэлнэ.

3.3.1 Сагсан бөмбөг:

- ◆ МСБХ-ноос Сагсан бөмбөгийн 2021-2022 оны “Янзтай нэгдсэн дээд лиг”-т оролцсон эрэгтэй тамирчид;
- ◆ МСБХ-ноос 2022 онд зохион байгуулагдсан “Gan Summer League”-т оролцсон эмэгтэй тамирчид;

3.3.2 Волейбол:

- ◆ МВХ-ноос 2021 онд зохион байгуулсан “Үндэсний Дээд Лиг”-д оролцсон эрэгтэй, эмэгтэй тамирчид;

3.3.3 Ширээний теннис:

- ◆ “Монголын ширээний теннисний холбоо”-ноос 2022 онд зохион байгуулагдсан Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон эрэгтэй, эмэгтэй тамирчид;

3.3.4 Шатар:

- ◆ “Монголын шатрын холбоо”-ноос 2022 онд зохион байгуулагдсан Насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон эрэгтэй, эмэгтэй тамирчид;

3.3.4 Дартс:

- ◆ 2022 онд зохион байгуулагдсан Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон эрэгтэй, эмэгтэй тамирчдыг тус тус хэлнэ.

3.4 Багууд нь тухайн спортын төрлийн 2 ээлжийн ижил хувцастай байна.

3.5 Хувцасны өнгө ижил эсвэл төстэй байх тохиолдолд талбайн эзэн баг тоглолтын өмсгөлийг солино.



- 3.6** Спортын их наадамд оролцох баг, тамирчдын эрүүл мэндийн болон хувь хүний осол гэмтлийн даатгалыг оролцогч байгууллага нь бүрэн хариуцна.
- 3.7** Баг тамирчид байрлах байр, хоол, тээврийн зардал, тэмцээнд оролцох болон зорчих үеийн аюулгүй байдлыг компани тус бүр бүрэн хариуцна.
- 3.8** Байгууллагын баг, тамирчид, хөгжөөн дэмжигчид спортын их наадмын журам, шүүгч болон зохион байгуулагчдын тавьсан шаардлагыг биелүүлж, сахилга батыг чандлан сахина.
- 3.9** Багууд сахилга батын болон зохион байгуулалтын зөрчил гаргасан тохиолдолд спортын их наадмаас хасах хүртэл арга хэмжээ авна.
- 3.10** Багууд спортын их наадмын нээлт, хаалтын үйл ажиллагаанд оролцоходоо өөрийн байгууллагын тугийг барьж жагсана.

ДӨРӨВ. СПОРТЫН ИХ НААДАМ ЯВУУЛАХ ЖУРАМ

- 4.1** Спортын их наадам нь 3 хүний бүрэлдэхүүнтэй шүүгчийн зөвлөлтэй байна. Үүнд:
- ◆ Ерөнхий шүүгч
 - ◆ Шүүгч
 - ◆ Шүүгч
- 4.2** Спортын их наадмыг тухайн төрлийн спорт холбоодын шүүгчдээр шүүн явуулна.
- 4.3** Талбайн шүүгчийн шийдвэр эцсийнх байна. Тэмцээнд ямар нэгэн маргаан гарвал баг тамирчдыг удирдаж байгаа багийн ахлагч шүүгчдийн зөвлөлд асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.
- 4.4** Тухайн багийн тоглогч /ажилтан/-ийн холбогдох нотлох баримтуудыг шалгаж, тэмцээнд оролцох эрх буюу мандат олгоно.
- 4.5** Спортын их наадмын үеэр үүссэн маргаантай асуудлыг тухай байгууллагын багийн ахлагчаар дамжуулан спортын их наадмын шүүгчийн зөвлөлд уламжилж шийдвэрлүүлнэ. Талбайн шүүгч зөвхөн тухайн тоглолттой холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.6** Гадны тамирчин оролцсон эсэхийг тухайн төрлийн тэмцээний шүүгч болон зохион байгуулах комисс тогтоох бөгөөд спортын их наадамд оролцогч багийн ахлагчаас бичгээр гаргасан хүсэлтээр дахин шалгаж болно.

4.7 Спортын их наадмын удирдамжийн 3.2, 3.3 дах заалтыг тус тус зөрчсөн багийг тухайн тоглолтод хожигдсонд тооцож, тэмцээнээс хасна. Улмаар өрсөлдөгч багт хожлыг өгнө.

4.8 Спортын их наадмын төрөл тус бүрийн тоглолт дараах байдлаар явагдана. Үүнд:

4.8.1 Сагсан бөмбөг:

- ◆ Хэсгийн тоглолтууд тойргоор явагдах бөгөөд эрэгтэй нэг талдаа цэвэр 10 минут, эмэгтэй нэг талдаа цэвэр 8 минутаар 2 үе явагдана.
- ◆ Шигшээ тоглолтууд хасагдах системээр явагдах ба эрэгтэй нэг талдаа цэвэр 10 минутаар, эмэгтэй нэг талдаа цэвэр 8 минутаар 2 үе явагдана.
- ◆ Оноо тэнцсэн тохиолдолд эрэгтэй 5 минут, эмэгтэй 3 минутаар явагдана.

4.8.2 Волейбол:

- ◆ Хэсгийн тоглолтууд тойргоор явагдах бөгөөд тоглолт 21 оноогоор 2 үе явагдана.
- ◆ Шигшээ тоглолтууд хасагдах системээр явагдах ба тоглолт 25 оноогоор 2 үе явагдана.
- ◆ Тоглолтын харьцаа тэнцсэн тохиолдолд 15 оноогоор гуравдугаар үе явагдана.

4.8.3 Ширээний теннис:

- ◆ Хэсгийн тоглолтууд тойргоор явагдаж хэсгээс 2 баг шалгарч, шигшээ тоглолтууд хасагдах системээр явагдана.
- ◆ Хэсгийн тоглолтонд 11 оноогоор 3 үе тоглох буюу түрүүлж 2 хожсон баг ялах ба шигшээ тоглолтонд 5 үе тоглоно.

4.8.4 Шатар:

- ◆ Тэмцээнийг швейцарь системээр явуулна.
- ◆ Тоглолтын үеийн цагийн хяналт талдаа 15 минут байна.

4.8.5 Дартс: /Тоглолтын бусад журмыг техникийн зөвлөгөөн дээр дэлгэрэнгүй танилцуулна./

- ◆ Холимог багийн төрлөөр явагдана.
- ◆ Баг, тамирчид сугалаагаар хэсэгт хуваагдана.
- ◆ Хэсгээс 2 баг шалгарч шигшээ тоглолтонд оролцоно.



ТАВ. ДҮГНЭХ, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

5.1 Спортын их наадмын нийлбэр оноог их онооны системээр тооцно. Аль нэг төрөлд оролцоогүй тохиолдолд тухайн төрлийн харгалзах оноог “0” гэж үзэн байгууллагын нийт дүнг гаргана. Үүнд:

Д/Д	СПОРТЫН ТӨРӨЛ	ХҮЙС	I БАЙР	II БАЙР	III БАЙР	IV БАЙР	V-VIII БАЙР	IX-XVI БАЙР	XVII БАЙР	XVIII БАЙР	XIX БАЙР
1.	ШАТАР	Эр	8	7	6	5	4	3	2	1	0.5
		Эм	8	7	6	5	4	3	2	1	0.5
2.	ШИРЭЭНИЙ ТЕННИС	Эр	8	7	6	5	4	3	2	1	0.5
		Эм	8	7	6	5	4	3	2	1	0.5
3.	САГСАН БӨМБӨГ	Эр	12	10	8	6	5	4	3	2	1
		Эм	12	10	8	6	5	4	3	2	1
4.	ВОЛЕЙБОЛ	Эр	12	10	8	6	5	4	3	2	1
		Эм	12	10	8	6	5	4	3	2	1
5.	ДАРТС	Холимог баг	16	14	12	10	8	6	4	2	1

5.2 Байгууллагын нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:

- ◆ Медалийн чанараар эрэмбэлнэ.
- ◆ Медалийн чанар тэнцсэн тохиолдолд волейбол, сагсан бөмбөг, ширээний теннис, шатар, дартс гэсэн дарааллаар эрэмбэлнэ.

5.3 Спортын их наадмын төрөлд тус бүрт эхний 3 байр эзэлсэн баг тамирчдыг медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнах ба спортын төрөл бүрт шилдэг тоглогчийг тодруулна. Эхний 3 байрт шалгарсан байгууллагуудад цом, өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулна.

5.4 Спортын их наадмын талаар 99010485, 88116333, 99094425, 99098863 дугаараас лавлана уу.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДЭРИЙН ЯАМ



УУРХАЙЧДЫН СПОРТЫН ИХ НААДАМ 2022

ҮҮРД ХАДГАЛАХ “ЦОМ”-ЫН ТӨЛӨӨХ
ОЛОН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН

